

Сэдвийн нэр: Өвөр байгалийн ой-ургамалжилтын мужийн ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх экологийн судалгаа

Удирдагч: Ойн нөөц, ой хамгааллын салбарын эрхлэгч, доктор, дэд проф Ц.Дашзэвэг

Ном зүйн тодорхойлолт:

“Өвөр байгалийн ой-ургамалжилтын мужийн ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх экологийн судалгаа” сэдэвт суурь судалгааны ажлыг 2008-2010 онд гүйцэтгэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаал гарснаар Шинжлэх ухаан, технологийн сан санхүүжүүлэн ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн хэрэгжүүлсэн болно. Сэдэвт ажлын үргэлжлэх хугацаа 3 жил бөгөөд 2010 оны 12 сарын 31-нээр дуусч байна. Энэхүү сэдэвт ажлын тайлан оршил, үндсэн 2 хэсэг, дүгнэлт, хавсралт бүхий 221 хуудастай ба нийт 126 зураг, 49 график, 4 бүдүүвч зураг, 23 томьёо, 96 хүснэгт орсон болно.

Сэдэвт ажлын тайланг Геоэкологийн хүрээлэнгийн ойн нөөц, ой хамгааллын салбарын эрдэмтэн, судлаачид 2010 оны 12-р сард бичив. Энэ тайлан ШУА-ийн Геоэкологийн хүрээлэнгийн өмч болно.

Бичвэр:

Монгол орны байгалийн болон өөрчлөгдөлд орсон ойн экологийн нөөцийг судлан харуулж, ойн нөөц баялагийг өнөө ба ирээдүйн эрх ашигт нийцүүлэн зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зорилгын үүднээс урт хугацааны мониторингийн судалгааны цэг байгуулж туршилт, судалгааг хийх, залуу судлаачдад судалгааны арга барил эзэмшүүлэх, судлаачдын залгамж халааг бэлтгэх явдал бидний эрхэм зорилго билээ. Ойн экосистем, түүний тэнцвэрт байдал алдагдалтанд нөлөөлж буй хүний үйл ажиллагааны болон байгалийн хүчин зүйлсийг илрүүлж, ойг зохистой ашиглах, хамгаалах, зориудаар нөхөн сэргээж, ойн нөөцийг нэмэгдүүлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулах зорилготой уг сэдэвт ажлыг гүйцэтгээд байна.

Ой судлал, ойн экологийн судалгааны эрдэмтэд, судлаачид 1970-аад оноос одоог хүртэл эрдэм шинжилгээний хайгуул болон суурин судалгаа явуулж, Монгол орны ой-ургамалшил; ойн хөрсний ангилал тогтоох; ойн усны горим зохицуулах; хөрс хамгаалах үүргийг илрүүлэх; ойн байгалийн сэргэн ургалт; ой үүсэн бүрэлдэх явцын онцлогийг тодорхойлох; ойн түймрийн аюул, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга зам болон ойн хөнөөлт шавжийн зүйлийн бүрдэл, зонхилох хөнөөлт шавжийн олшролын биологийн онцлогийг илрүүлж, тэмцэх арга хэмжээний үндэслэл гаргах; мод, сөөгний тарьц, суулгац ургуулах, ойг зориудаар нөхөн сэргээх, ойжуулах агротехник, технологи боловсруулах зэрэг чиглэлээр хэд хэдэн шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгааны сэдэвт ажил гүйцэтгэж ирсэн ба эрдэм шинжилгээний олон арван бүтээл туурвисан байна.

Өмнөх судалгааны үр дүнгийн үргэлжлэл болгож, уг сэдэвт ажлын зорилгыг улам нарийвчлан гүйцэтгэж байгаа учраас бид хүн амын төвлөрөл ихтэй, авто болон төмөр замын сүлжээ хөгжисөнтэй уялдан, ойн сангийн талбайг ихээхэн өөрчлөгдөлд орсон “Өвөр байгалийн ой-ургамалжилтын муж”-ийн ойг судалгааны объект болгон сонгосон болно.

Холбоо барих хаяг: 976-11-325680

